

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2009 оны 11 сарын 30-ны өдөр

дугаар 03

Улаанбаатар хот

Давж заалдах журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мэтгэлцээний талаарх хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай

Давж заалдах журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3., 15.4.-т заасныг баримтлан Улсын Дээд шүүхээс **ЗӨВЛӨМЖ болгох нь:**

Нэг: Давж заалдах журмаар мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг хянах зарим асуудал

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд шүүхийн өмнө өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалахдаа мэтгэлцэх зарчмыг үндэслэл болгодог. Энэ зарчим нь шүүхэд мэдүүлэх эрх, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байх, шүүх хуралдаан хуулиар тогтоосон журмын дагуу явагдах, хэргийн оролцогчдын хуулиар тогтоосон эрх үүрэг хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зэрэг бүхий л ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-т заасан мэтгэлцэх зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд бусад суурь зарчмуудтай харилцан уялдаа, холбоотойгоор хэрэгжинэ гэж үзнэ.

1. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэртэй хэргийг хянахдаа дараах арга хэлбэрээр мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг анхаарах шаардлагатай.

1.1. Хэргийн үйл баримт, зохигчдын гэм бурууг нотлох буюу үгүйсгэх нотлох баримтыг хэргийн оролцогч өөрөө бүрдүүлэх үүрэгтэй тул хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан арга хэлбэрээр олж авсан эсэхийг шүүх нягтлан үзнэ.

Шүүх хуралдаанаас өмнө цуглуулсан нотлох баримтын талаар зохигчид шүүх хуралдаан дээр мэтгэлцэхээс гадна зохигчдын мэдүүлэг мөн мэтгэлцээний үндэс болох тохиолдлыг анхаарах шаардлагатай. Мэтгэлцээн нь ярилцлага, тайлбарын хэлбэртэй явагдахын зэрэгцээ талуудын гаргасан нотлох баримтын хүрээнд л болох ёстойг анхаарвал зохино.

1.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.-д зааснаар зохигчийн хүсэлтээр хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг шүүх бүрдүүлдэг ба энэ ажиллагаа зохигчдын шүүхэд гаргасан хүсэлтээр хийгддэг. Шүүх хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд дээрх ажиллагааг явуулж нотлох баримт бүрдүүлж байгаа нь талуудын мэтгэлцэх боломжид дэмжлэг үзүүлж байгаа хэлбэр юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдоос гаргаж буй хүсэлтийг шүүх хангасан эсэх асуудал нь чухал ач холбогдолтой. Нотлох баримт бүрдүүлэх талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт бүрийг шүүх хангах учиргүй боловч хүсэлтийг заавал хянан хэлэлцэж хангах эсэх талаар шийдвэрлэсэн байх ёстой.

Анхан шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдол бүхий нотлох баримт гаргуулах талаар зохигчийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг давж заалдах шатны шүүх нягтлан үзэх шаардлагатай. Зохигчдын хүсэлтийг шүүх хангасан, эсхүл хэрэгсэхгүй болгосон асуудал нь хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт хийхийн зэрэгцээ шүүх хуульд заасан эрх хэмжээний

хүрээнд нотлох баримт бүрдүүлж оролцохдоо талуудын маргаантай харилцааны үйл баримтад хөндлөнгийн байр суурьтай оролцож чадсан эсэхийг анхаарвал зохино.

1.3.Зохигч шүүх хуралдааны бүх шатанд биеэр оролцох, үг хэлэх, эсрэг талын болон өөрийн гаргасан нотлох баримтад бичгээр тайлбар гаргах, хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой асуулт тавьж, хариулт авах зэрэг хэлбэрээр мэтгэлцэж оролцдог тул энэ эрх нь хуульд заасан журмын дагуу хангагдсан эсэхийг нягтлан үзэх шаардлагатай.

1.4.Шүүх зохигчдын мэтгэлцээнд төвийг сахисан байр сууринаас хандаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан зохион явуулахдаа талуудыг тэгш эрхтэйгээр оролцуулах үүргийг хүлээдэг тул талуудын мэтгэлцэх замаар бие биенээ ялан гарах гэсэн өрсөлдөөнийг хянан зохицуулах ажиллагааг хуулийн хүрээнд явуулсан эсэхийг анхаарвал зохино.

Энэ нь шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байх, хэргийн бодит үнэнийг тогтоож, хуульд нийцсэн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой болно.

Хоёр: Давж заалдах шатны шүүхээс мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх ажиллагаа

Давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхэд анхан шатны шүүхтэй харьцуулахад хийх ажиллагаа, эдлэх эрх, хүлээх үүргийн хувьд арай хязгаарлагдмал байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4.-т зааснаар давж заалдах шатны шүүх талуудын гаргасан гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлахгүй хэргийг бүхэлд нь хянадаг учир зохигчдын хооронд явагдсан мэтгэлцээнээр маргааныг нотолсон болон үгүйсгэсэн үйл баримтад хуульд нийцүүлэн дүгнэлт хийх ёстой.

Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан нэг цогц ажиллагаа тул давж заалдах шатанд талуудын мэтгэлцэх эрхийг хангах шүүхийн ажиллагааг дараах төрлүүдээр ангилан үзэж болно.

2.1.Давж заалдах шатны шүүх хуралдаанд зохигчдыг оролцуулах хэлбэрээр мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 165 дугаар зүйлийн 165.1.-д зааснаар зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохыг бичгээр хүсвэл шүүх давж заалдах шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэх үүрэгтэй. Иймд хэргийн зохигч, оролцогчид шүүхэд хүсэлт гаргасан тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан ажиллагааг шүүх хийх үүрэгтэй.

2.2.Шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг бүхэлд нь шинжлэн судалсны үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэхдээ зохигчдын тайлбар, нотлох баримтууд нь зохигчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн харилцааны маргааныг хэрхэн нотолж, үгүйсгэн мэтгэлцсэн байдалд дүгнэлт хийж, өөрийн шийдвэр гаргах үндэслэлээ болгодог.

Энэ нь анхан шатны шүүхтэй адилгүй боловч зохигчдын мэтгэлцээний үр дүнд шүүх хэргийг хуульд нийцүүлэн шийдвэрлэж чадсан эсэхийг тогтоодог онцлогтой. Талууд нотлох баримтын үндсэн дээр өөрсдийн байр суурийг өрсөлдөн нотлох хэлбэрээр мэтгэлцээний агуулгыг илэрхийлдэг болно.

Иймд давж заалдах шатны шүүх хуралдаанд хэргийн оролцогчдыг оролцуулан мэтгэлцүүлэхээс гадна анхан шатны шүүх дээр явагдсан мэтгэлцээний үр дүнг хуульд нийцүүлэн тодорхойлно.

2.3.Давж заалдах шатны шүүхэд явагдах мэтгэлцээний нэг үндэслэлд зохигчдын давж заалдах гомдол болон түүнд өгсөн хариу тайлбар хамаарна.

Давж заалдах гомдлыг нөгөө талд нь танилцуулах, хариу тайлбар гаргаагүй тохиолдолд тайлбар гаргах эрхтэй болохыг мэдэгдэх, өмгөөлүүлэх эрхийг хангах, хэргийн материал, нотлох баримттай дахин танилцах боломжийг хангах зэргээр талуудын мэтгэлцэхэд хуульд нийцсэн таатай нөхцөлийг бүрдүүлж өгөх асуудал анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаанд

хоёуланд нь хамааралтай. Учир нь зарим ажиллагаа анхан шатны шүүхэд хийгдэж байхад зарим нь давж заалдах шатны шүүх дээр хийгддэг учир дээрх ажиллагааг хуулийн дагуу явуулахыг хоёр шатны шүүх анхаарах шаардлагатай.

2.4. Давж заалдах шатны шүүх хуралдаанд гомдол гаргасан зохигч оролцож байгаа тохиолдолд гомдлыг өөрөөр нь тайлбарлуулах, оролцоогүй тохиолдолд шүүгч давж заалдах гомдлыг уншин сонсох, үүний дараа хариу тайлбарыг сонсох, гомдол гаргаагүй тал шүүх хуралдаанд оролцоогүй бол бичгээр гаргасан хариу тайлбарыг шүүх уншин сонсох зэрэг хэлбэрээр үйл баримтыг судлах нь талуудын мэтгэлцээнийг үргэлжлүүлэх хэлбэр бөгөөд энэ нь шүүхийн дүгнэлт гаргах үндэслэлийн нэг хэсэг болно

Ашиг сонирхлын зөрчилдөөнтэй хоёр талыг шүүх хуралдаанд оролцуулан мэтгэлцүүлэхийн тул шүүх хуулиар тогтоосон бүхий л арга хэмжээг авбал зохино.

Гурав. Давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд талуудын мэтгэлцээний үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарвал зохих зарим асуудал

Давж заалдах шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэхдээ зохигч, хэргийн оролцогчдын мэтгэлцэх боломжийг хангах болон анхан шатны шүүх иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлж буй байдлын талаарх аймаг, нийслэлийн шүүхүүдээс ирүүлсэн санал, хүсэлтэд тулгуурлан дараах чиглэлд анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

3.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.4.-т зааснаар хэргийн оролцогч давж заалдах гомдлын үндэслэлдээ анхан шатны шүүхээр хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй бөгөөд ийм нотлох баримт гомдолд заагдсан бол мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5.-д зааснаар давж заалдах шатны шүүх уг нотлох баримтыг үнэлэхгүй буюу судлан дүгнэлт хийх эрхгүй болно.

Зарим тохиолдолд анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй баримтыг давж заалдах гомдолд хавсаргасныг анхан шатны шүүх хүлээн авдаг, давж заалдах шатны шүүх түүнийг үнэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчдөг, мөн тухайн нотлох баримтыг үнэлээгүй мэт боловч, шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлд хамааруулдаг. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын мэтгэлцэх үндсэн дээр явагдах зарчмыг давж заалдах шатны шүүхээс зөрчсөн алдаанд тооцогдоно.

Нөгөө талаар, шүүхээр хянан хэлэлцэгдсэн, хэрэгт авагдсан нотлох баримтыг гомдолд хавсаргаснаар нь дахин хэрэгт хийх шаардлагагүйг анхаарвал зохино. Шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдээгүй нотлох баримтыг давж заалдах шатны шүүх хүлээн авч дүгнэх эрх зүйн боломжгүй талаар тухайн гомдол гаргагчид тайлбарлан өгч, хууль зүйн талаас сайн ойлгуулах, нотлох баримтуудыг хүлээн авахгүй байх нь анхан шатны шүүхийн үүрэг болно. Нэгэнт хүлээн авсан тохиолдолд (шуудангаар ирүүлсэн) давж заалдах шатны шүүх энэ байдалд дүгнэлт хийх учиртай.

3.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1.-д заасны дагуу давж заалдах шатны шүүх хуралдааны ирцийг хуралдаан эхлэхээс өмнө бүртгэж, хуралдаанд оролцох эсэх, мэдэгдэх хуудас хэдийд яаж хүргүүлсэн талаар тодруулгыг авч шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангахад шүүхийн тамгын алба, хэлтэс, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга зэрэг тухайн ажлыг хариуцсан ажилтан анхаарах учиртай.

Энэ ажиллагааг учир дутагдалтай явуулдгаас шүүх бүрэлдэхүүн ялангуяа хуралдаан даргалагч шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хийвэл зохих ажиллагааг явуулж, ирц бүртгэдэг, шүүх хуралдааны бэлтгэл ажилд оролцдог зэрэг зөрчлийг арилгах шаардлагатай.

Давж заалдах шатны шүүх хуралдааныг эртнээс товлож, шүүхийн мэдээлэл, вэб сайтад байрлуулах, мэдээлэл лавлагааны ажилтан хуралдааны зарыг нийтэд мэдээлэх зэрэг ажлыг хариуцлагатай явуулах, зохигчдод аль болохоор хуралдааны товыг эрт мэдэгдэх нь зүйтэй.

3.3. Давж заалдах шатны шүүх хуралдаанд хэргийн оролцогч хүрэлцэн ирээгүй тохиолдолд мэтгэлцээн огт байхгүй гэх ойлголт буруу бөгөөд анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа хуульд заасан мэтгэлцэх боломжийг олгосон эсэх, хэргийн үйл баримтын талаар талууд хэрхэн мэтгэлцсэн, нотлох баримтын нотлох болон үгүйсгэх байдал зэрэгт давж заалдах шатны шүүх дүгнэлт өгч байгаа нь давж заалдах шатны шүүх хуралдаанд талуудын мэтгэлцээн үргэлжилсээр байгаа гэж ойлгоно.

Шүүх хуралдаанаар давж заалдах гомдол, түүнд гаргасан хариу тайлбар, гомдлын үндэслэл нь хэрэгт авагдсан нотлох баримтаар хэрхэн үгүйсгэгдэж, нотлогдож буйд шүүх бүрэлдэхүүн эрх зүйн дүгнэлт хийх ажиллагаа ч өөрөө мэтгэлцээний агуулгыг тодорхойлдог.

Мөн давж заалдах шатны шүүхэд хэрэг ирсний дараа зохигч, хэргийн оролцогчид хэргийн материалтай танилцах, бичгээр тайлбар гаргах, шүүх хуралдааны товьг зохигч, оролцогчдод мэдэгдэх, өмгөөлөх эрхээр хангах, орчуулагч, хэлмэрч авах, солих зэрэг ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд тэгш эрхтэйгээр оролцож, мэтгэлцэх боломж олгож буй шүүхийн үйл ажиллагаанд хамааралтай юм.

Хэргийн оролцогчдын эрх зүйн мэдлэг дутмаг байдал мэтгэлцээнд бүрэн оролцохгүй байх хандлагыг бий болгодог хэдий ч шүүх зохигчдын эрх, үүргийг тайлбарлахдаа мэтгэлцээнд хэрхэн оролцох талаар сайн тайлбарлаж өгөх шаардлагатай.

Шүүх хэргийн оролцогчдод эрх, үүргийг нь тайлбарлах ажиллагааг хэрэгт баримт хавсаргах зорилгоор биш харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын мэтгэлцэх зарчмын үндсэн дээр оролцох ажиллагааг бодит, үр дүнтэй болгох зорилгоор зохион байгуулах нь зүйтэй байна.

Шүүх мэтгэлцэх зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэхийн тулд хэргийн оролцогчийг энэ ажиллагаанд хэрхэн оролцуулж, ойлгуулж чадсанаар мэтгэлцээний үр дүн гарна.

Мэтгэлцээн бол маргааны зүйл, үйл баримтыг зөвшөөрөх, татгалзах байдлаа нотолж буй талуудын хууль ёсны үйл ажиллагаа болохоос биш хий хоосон маргаан, хэрүүл биш гэдгийг зохигчдод ойлгуулах, нэн ялангуяа өмгөөлөгч нарын мэргэжлийн ур чадварын түвшин, ёс зүйн байдал мэтгэлцэх ажиллагаагаар илэрдгийг анхааруулах нь чухал.

3.4. Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримтуудыг нотлох болон үгүйсгэх талаас нь тодорхой тусгаж, хуульд нийцсэн дүгнэлт хийх шаардлагатай. Шүүх зохигчдын гаргасан нотлох баримтыг нотлох буюу үгүйсгэх замаар хэрхэн мэтгэлцсэн байдлыг шийдвэрийн үндэслэх хэсэгт заасан байвал зохино.

Судалгаанаас үзвэл шүүхийн гаргаж буй шийдвэрт нэхэмжлэлийг хангасан бол зөвхөн нотолсон баримтыг дүгнэдэг, хэрэгсэхгүй болгосон бол үгүйсгэсэн баримтыг л түүж дүгнэдгийг учир дутагдалтай гэж үзнэ. Талуудын гаргасан баримтуудыг хэрхэн үнэлсэн талаар бүрэн дүгнэлт хийлгүй орхигдуулсан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь илүү түгээмэл байдаг.

3.5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1.-д заасны дагуу давж заалдах шатны шүүх хуралдааныг анхан шатны шүүх хуралдааны журмын нэгэн адил явуулдаг. Иймд мөн хуулийн 108 дугаар зүйлийн 108.2.-т заасны дагуу нотлох баримтыг шинжлэн судлах, асуулт тавих дараалал нь хуулийн 166 дугаар зүйлийн 166.5.-д заасан хэргийн материал судлах ажиллагаанд хамааралтай учир давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүх бүрэлдэхүүн асуулт тавих эрхтэй болно.

3.6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.-д заасны дагуу маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцвол мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.-д зааснаар зохигч гэж үзнэ. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд зохигчийн эрх эдэлж, үүрэг хүлээж оролцохдоо нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэж байгаа үндэслэлээ нотлох замаар мэтгэлцэж оролцоно.

Харин бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо нэхэмжлэгч хариуцагчийн аль нэг талын шаардлага, татгалзлыг дэмжиж оролцдог хэдий

ч нотлох баримт гаргах эрхтэй этгээдийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцээнд өөрийн бие даасан байр сууринаас биш ч зохигчдын байр сууринаас оролцдогийг анхаарвал зохино.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ